



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 23 өдөр

Дугаар А/605

Булган сум

### Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дүгээр зүйлийн 60.1.9 дэх заалт, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны “Шинэ хөгжлийн зам” хөтөлбөрийг батлах тухай аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны II/04 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын А/593 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Бүгд Найрамдах Солонгос Улсын Кёнги аймгийн Шинхан Их Сургуулийн Тусгай хэрэгцээт боловсролын сургуулийн багш нарын сургалт, арга хэмжээний хөтөлбөрийг нэгдүгээр, төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Сургалт, арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах 6,705,800 (зургаан сая долоон зуун таван мянга найман зуу) төгрөгийг Гадаад арга хэмжээ зохион байгуулах хөтөлбөр, төлөвлөгөө хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Алтаншагай)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Алтаншагай)-т зөвшөөрсүгэй.

Аймгийн Засаг даргын 2023 оны  
08 дугаар сарын 23-ны өдрийн 1/605 дугаар  
захирамжийн 1 дүгээр хавсралт

БНСУ-ЫН КЕНГИ АЙМГИЙН ШИНХАН ИХ СУРГУУЛИЙН ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭТ  
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН СУРГАЛТ, УУЛЗАЛТЫН ХӨТӨЛБӨР

Цаг	Үйл ажиллагаа	Хаана	Хариуцах эзэн
<i>2023 оны 08 дугаар сарын 09-ны өдөр, Пүрэв гараг</i>			
10:00-10:30	Зочдыг угтаж авах	Улаанбаатар хот	Ж.Ганболд
10:30-11:30	Нисэх-Улаанбаатар ирэх	Баянгол ресторан	
11:30-13:00	Өдрийн хоол	Баянгол ресторан	
13:00-19:00	УБ-Дархан-Эрдэнэт чиглэлд зорчих	-	
19:00-20:00	Оройн хоол	Эрдэнэт хот	
20:00-21:00	Эрдэнэ-Булган чиглэлд зорчих	-	
21:00	Буудалд байрлах, амрах	"Булган" зочид буудал	
<i>2023 оны 08 дугаар сарын 10-ны өдөр, Баасан гараг</i>			
09:00-10:00	Өглөөний цай	"Булган" зочид буудал	-
10:00-11:00	Сургалт, хэлэлцүүлгийн бэлтгэл	БШУГ	Г.Нансалмаа Г.Чинзориг
11:00-13:00	Тусгай хэрэгцээт боловсролын сургалт	БШУГ	Багш нар
13:00-14:00	Өдрийн хоол	"Жаран" зоогийн газар	Н.Хүрэлсүх
14:00-16:00	Тусгай хэрэгцээт боловсролын сургалт	БШУГ	Багш нар
16:30-18:00	Шинхан их сургуульд суралцах сурагчдын танилцуулга, үсэглэлийн хаалтын үйл ажиллагаа	Соёлын ордон	Г.Нансалмаа С.Буянзаяа Ж.Гэрэлмаа
18:00-19:00	Оройн хоол	"Жаран" зоогийн газар	Н.Хүрэлсүх
19:00	Чөлөөт цаг, амралт	"Булган" зочид буудал	-
<i>2023 оны 08 дугаар сарын 11-ний өдөр, Бямба гараг</i>			
09:00-10:00	Өглөөний цай	"Булган" зочид буудал	-
10:00-12:00	Тусгай хэрэгцээт боловсролын сургалт	БШУГ	Г.Нансалмаа
12:00-13:00	Өдрийн хоол	"Жаран" зоогийн газар	Н.Хүрэлсүх
13:00-15:00	Тусгай хэрэгцээт боловсролын сургалт	БШУГ	Г.Нансалмаа
15:00-16:00	Хэлэлцүүлэг	-	Ж.Ганболд
16:00-18:00	Булган-Уран тогоо явах	-	Ж.Ганболд
18:00-19:00	Оройн хоол	"Жаран" зоогийн газар	Н.Хүрэлсүх
19:00	Чөлөөт цаг, амралт	"Булган" зочид буудал	-
<i>2023 оны 08 дугаар сарын 12-ны өдөр, Ням гараг</i>			
09:00-10:00	Өглөөний цай	"Булган" зочид буудал	-
10:00-11:00	Зочдыг үдэх	Булган-Улаанбаатар	Ж.Ганболд

Аймгийн Засаг даргын 2023 оны  
08 дугаар сарын 23-ны өдрийн А.У.Б.О.С дугаар  
захирамжийн 2 дугаар хавсралт



БНСУ-ЫН КЁНГИ АЙМГИЙН ШИНХАН ИХ СУРГУУЛИЙН ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭТ  
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН СУРГАЛТ, УУЛЗАЛТЫН ТӨСӨВ

Д/д	Зардлын нэр	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт дүн /төг/
<b>1.Шатахуунын зардал</b>				
1	Угтаж, үдэх шатахуун Улаанбаатар-Дархан-Эрдэнэт- Булган Булган-Эрдэнэт-Дархан – Улаанбаатар	415л	2,520	1,045,800
	<b>Нийт</b>			<b>1,045,800</b>
<b>2.Байр, хоолны зардал</b>				
1	Зочид буудал /Булган аймаг/	4	280,000	1,120,000
2	Зочид буудал /Улаанбаатар/	2	380,000	760,000
3	Хоол / Булган /	35	25,000	875,000
4	Замын хүнс	12	30,000	360,000
5	Зочид буудлын өрөөнд хүнс /Айраг, ааруул, ус ундаа, хүнс/	2	150,000	300,000
6	Хоол / Дархан /	6	50,000	300,000
7	Хоол / Эрдэнэт /	6	70,000	420,000
8	Сургалтын цайны зардал	35	3,000	105,000
9	Хүлээн авалт / Урантогоо/	1	600,000	600,000
10	Оройн хоол / Улаанбаатар/	6	70,000	420,000
	<b>Нийт</b>			<b>5,260,000</b>
<b>3. Бэлэг дурсгал</b>				
1	Хүндэтгэлийн бэлэг /Солонгос багш нар/	4	100000	400,000
	<b>Нийт</b>			<b>400,000</b>
				<b>6,705,800</b>